




Говь-Алтай аймгийн Бичил уурхайн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал



Аймгийн Засаг даргын Орлогч Ж.Ганбат



Говь-Алтай аймаг нь 141.4 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, Монгол Улсдаа газар нутгийнхаа хэмжээгээр 2-т ордог.



• Засаг захиргааны 18 сум, 87 багтай

• Нийт 16072 өрх, 56018 хүн амтай.

6903 малчин өрхтэй. 13294 малчинтай.

Улаанбаатар хотоос 1000 гаруй км алслагдсан


Нутаг дэвсгэрийн 51% тусгай хамгаалалттай



Геологи, Уул уурхайн салбар Говь-Алтай аймагт

Говь-Алтай аймагт 83 орд, 680 гаруй илрэлүүд мэдэгдээд байна.

Геологийн судалгааны хувьд 1959-1960-аад оноос эхэлсэн ба 1:200 000 масштабтай геологийн зураглалаар 100 хувь бүрхэгдсэн, 1:50 000 масштабтай геологийн зураглалын ажилд газар нутгийн 30 орчим хувь нь хамрагдаад байна.





Бичил уул уурхайг хөгжүүлэхэд баримталж буй бодлогын баримт бичгүүд

- ▶ Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого
- ▶ Алт-2 үндэсний хөтөлбөр
- ▶ ЗГ-ын 151 дүгээр тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам
- ▶ Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- ▶ Жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл



Тусгай зөвшөөрөл


Аймгийн хэмжээнд ашигт малтмалын хүчин төгөлдөр 186 тусгай зөвшөөрөл нийт нутаг дэвсгэрийн 6.8 хувийг эзлэж байна.

№	Он	Бүгд			Үүнээс:					
					Ашиглалтын тусгай зөвшөөрөл			Хайгуулын тусгай зөвшөөрөл		
		Тусгай зөвшөөр-лийн тоо	Талбайн хэмжээ Мян.га	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөр-лийн тоо	Талбайн хэмжээ Мян.га	Нутаг дэвсгэрт эзлэх хувь	Тусгай зөвшөөр-лийн тоо	Талбайн хэмжээ Мян.га	Нутаг дэвсгэрт эзлэх хувь
3	2013	138	1973.8	13.9	18	4.4	0.0	120	1969.3	13.9
4	2014	128	1184.3	8.4	27	25.4	0.2	101	1158.8	8.2
5	2015	207	1479.3	10.4	28	25.5	0.2	179	1453.7	10.2
6	2016.11	198	1431.7	10,1	43	66.2	0.46	155	1365.5	9.6
7	2017.11	183	967.2	6.8	47	67.5	0.47	136	899.7	6.36



Аймгийн хэмжээнд ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон 47 ордыг төрлөөр нь авч үзвэл:

Ашигт малтмалын төрөл





Орон нутгаас баримтлаж буй бодлогын баримт бичгүүдэд бичил уурхайн чиглэлээр туссан зорилт :

- ▶ Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг дэмжих;
- ▶ Эвдрэлд орж орхигдсон газруудын тооллого судалгааны ажлыг зохион байгуулах замаар нөхөн сэргээлт хийлгэх, бичил уурхайгаар ашиглах боломжтой газруудыг тодорхойлох;
- ▶ Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох газрын асуудлыг шийдвэрлэх ;
- ▶ Хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газруудад нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хийлгэх /жил бүр 10-аас доошгүй га газар/;



Зохион байгуулалтанд оруулах

Аймгийн хэмжээнд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зорилгоор зохион байгуулалтанд орсон 1 холбоо, 9 төрийн бус байгууллага, 24 бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй нөхөрлөл, 284 бичил уурхайчид бүртгэгдээд байна.





Бичил уурхайг хөгжүүлэх чиглэлээр

Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдийг бичил уурхайн зохион байгуулалтанд оруулж, дэмжин ажиллах чиглэлийг хүргүүлэн ажиллаж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхайн төсөл”-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна.

“Бичил уурхайн эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт сургалт болон туршлага судлах уулзалтуудыг зохион байгуулж байна.

Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлыг орон нутаг төсөл хөтөлбөрийн хамтарсан санхүүжилттээр хийлгэж байна.





- Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэд, нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааг таслан зогсоох хөөх, хууль журмын хүрээнд ажиллах эрхзүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг авч ажиллаж байна.





Эвдэрсэн газрын тооллого

Тооллого судалгааны ажлын үр дүнд 15 сумын 159 газрын 415.26 га газар эвдрэлд орж орхигдсон байна.


Эвдрэлийн төрөл /хувиар/






Эвдрэлд орж орхигдсон нийт талбайн 73 хувь буюу 263.93га-д цаашид нөхөн сэргээлт хийх шаардлагатай байгаа боловч 79 хувь нь давхцалтай байна.

Нөхөн сэргээлт хийх шаардлагатай
эсэх /га-аар/



■ Шаардлагатай ■ Шаардлагагүй

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл,
Ой, усны сан бүхий газар болон Тусгай
хамгаалалттай газар нутагт давхцалтай эсэх
/хувиар/



■ Давхцалтай ■ Давхцалгүй



Бичил уурхайн газрын асуудал



2017 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 79

Есөнбулаг сум

Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах
санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12.1.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бичил уурхайн зориулалтаар тусгай хэрэгцээнд авахаар сумдаас ирүүлсэн хавсралтад дурдсан солбицол бүхий газруудыг Ашигт малтмал, газрын тосны газарт уламжлан, "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг баримтлан аймгийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдуулан хэрэгжилтийг яаралтай зохион байгуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

2. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллаж үр дүн, тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд хагас, бүтэн жилээр танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

- Эвдэрсэн газрын тооллого судалгааны үр дүнд үндэслэн 71 газрыг бичил уурхайгаар ашиглах боломжтой эсэх талаар лавлагаа авахаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст хүсэлт гаргаад байна. /Тус газраас холбогдох хүмүүс ирсэн тул тодорхой мэдээлэл өгөх болно./



Нөхөн сэргээлт

Орон нутгийн төсөв болоод төсөл хөтөлбөр, бичил уурхайн журмын хүрээнд 2014-2017 онуудад нийт 83.15 гад нөхөн сэргээлт хийсэн байна.

Нөхөн сэргээсэн газрын хэмжээ	2014 он	2015 он	2016 он	2017 он
	42.85 га	19.5 га	9.8 га	11 га





Тулгамдаж буй асуудлууд

- Хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэдийг бичил уурхайн зохион байгуулалтанд оруулах ажлыг эрчимжүүлэх.
- Бичил уурхайгаар ажиллах газрын асуудлыг нэгдсэн бодлогоор шийдвэрлэж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулж эхлэх.



Тулгамдаж буй асуудлууд

- Нөхөн сэргээлт нэрийн дор ашигт малтмал олборлох аливаа гэрээ хэлцэл байгуулахгүй байх, илэрсэн тохиолдол таслан зогсоож хуулийн хариуцлага хүлээлгэх.
- Бичил уурхай нэрийн дор хүчин чадал өндөртэй техникээр хуулиар хориглосон газруудад хууль бусаар ашигт малтмал олборлож буй үйл ажиллагааг таслан зогсоох.
- Хууль бус химийн болон тэсрэх бодисын хэрэглээг таслан зогсоож байгальд ээлтэй арга технологээр үйл ажиллагаа явуулах



Тулгамдаж буй асуудлууд

- Баяжуулах цехийн байршил, үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичгийг гаргаж орон нутагт чиглэл өгөх.
- Алт борлуулалтын сүлжээг албажуулах ажлыг зохион байгуулах.
- Бичил уурхайн нөхөн сэргээлтийг аргачлалын дагуу хийлгэн хүлээлэн авах.
- Бичил уурхайн эрх зүйн орчин болоод холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллах.



**Анхаарал хандуулсан та
бүхэнд баярлалаа**